Төрийн албаны зөвлөлийн 2019
оны 03 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДУУДЛАГЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ЖОЛООЧЫН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Дөлгөөн 2023 оны Б/305

Дагаж мөрдөх огноо: 2025.05.29.

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2025.05.29.

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Зоонозын Өвчин судлалын үндэсний төв	Санхүү, хангамж үйлчилгээ, нөөцийн алба
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл:
Дуудлагын түргэн тусламжийн жолооч	ТҮЭМ 2-5
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
8.30-15.30 6цаг	СХД-ийн 20-р хороо, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн өөрийн байр
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн бус	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Тандалт, судалгаа болон яаралтай дуудлага, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажилд явахад тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, техник үйлчилгээг тогтмол хийж аюулгүй байдлыг хангаж, түргэн шуурхай бэлэн байдлыг ханган ажиллах

Албан тушаалын зорилт:

1. Тандалт, дуудлага болон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг ханган, осол аюулгүй үйлчилгээ үзүүлэх
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж, мэдлэг, мэргэжлээ тасралтгүй дээшлүүлж, өөрийгөө хөгжүүлэх
3. Бусад

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - **Т**, Хариуцан гүйцэтгэх - **Г** Хянах – **Х** Шийдвэрлэх – **Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	➢ Ажилд гарахын өмнө эзэмшиж буй автомашиныхаа тоормоз, асаалт, цахилгаан, хөргөлтийн болон тосолгооны системийн хэвийн ажиллагаанд үзлэг хийж авто механикад танилцуулж ажилд гарах зөвшөөрлийг авна.	Ажил гүйцэтгэхэд бэлэн болсон байна.	Г
	➢ Замын хуудас болон дагалдах хуудсаар шатахууны болон бусад тооцоог дараа сарын 5-ны өдрийн дотор санхүүтэй хийсэн байх.	Биечлэн гүйцэтгэнэ.	Г
	➢ Дуудлаганд үйлчилсэн тухай бүр албан тушаалтнаар замын хуудсанд гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх	Баталгаажуулалт хийлгэсэн байна.	Г
	➢ Автогражийн цэвэрлэгээ, хаалга, цонхны бүрэн бүтэн байдал, цахилгаан, дулааны хэвийн ажиллагаанд хяналт тавьж, засвар үйлчилгээ, цэвэрлэгээг хийнэ.	Бүхэлд нь болон хуваарьт талбайг хамрана.	Г
	➢ Автомашины эвдрэл гэмтлийг өөрийн мэдлэг чадварын түвшинд засварлан техникийн үе шатны үйлчилгээг нормт цаг хугацаанд нь хийнэ.	Биечлэн гүйцэтгэнэ.	Г
	➢ Автомашиныг гадны засварын байгууллагаар хийлгэх тохиолдолд газар дээр нь байнгын хяналт тавьж засвар дууссны дараа техникийн комисст /автомеханик/ мэдэгдэн хүлээн авч солиулсан сэлбэгийг няравт тушаах.	Өөрийн биеэр хянана.	Х
	➢ Автомашины эвдрэл гэмтэл бүрт техникийн комиссын бүрэлдэхүүнээр эвдрэлийн шалтгаан нөхцлийг баталгаажуулан акт тогтоолгоно.	Акт баталгаажсан эсэхэд хяналт тавина.	Х
	➢ Алсын болон хот орчмын дуудлага, шинжилгээ, тандалт судалгаа, аж	Биечлэн хариуцана.	Г
		Биечлэн	г

	ахуй хангамж үйлчилгээний ажил гүйцэтгэх үүрэг авсан тухай бүр хариуцсан ажлаа чанартай, аваар осолгүй хийж гүйцэтгэнэ. ➢ Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний үүргийг биелүүлнэ.	гүйцэтгэнэ.	
2 дугаар зорилтын хүрээнд	ЭМС-ын 2019 оны А/406 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм -Хүнлэг энэрэнгүй байх зарчмын хүрээнд:Хүний эрүүл мэнд, сайн сайхны төлөө анхаарал тавих, хүн бүрийг энэрэн хайрлах, асрах, тусалж дэмжих; -Хүндэтгэлтэй хандах зарчмын хүрээнд: Хүний язгуур эрхийг хүндэтгэн хамгаалах, сонсох, өөрийн бодол санааг зөв ойлгуулах, хүлээцтэй харилцах, эелдэг, даруу төлөв байх, нууцыг хадгалах; -Чин үнэнч, шударга байх зарчмын хүрээнд: Хууль ёсыг чандлан сахиж, дүрэм, журмыг биелүүлж, төвшин шударга, эв нэгдэлтэй байх; -Хүн бүрт тэгш хандаж, үл ялгаварлах зарчмын хүрээнд: Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй, үйлчлүүлэгч бүрт адил тэгш хандах; -Хариуцлагатай байх, боловсорч хөгжих хүрээнд: Хөдөлмөрч, хичээнгүй, даруу төлөв, нямбай, мэргэжлийн ур чадвартай байх, насан туршдаа сурч боловсорч, мэдлэг, мэргэжлээ байнга дээшлүүлэх;	Мөрдөн ажиллана.	Г Г Г Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	➢ Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж биелэлтийг баталгаажуулж байна. ➢ Хариуцсан автомашиныхаа ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээг хийнэ. ➢ Байгууллагын соёлыг сайжруулах	Биечлэн гүйцэтгэнэ. Биечлэн гүйцэтгэнэ. Биечлэн	Г Г

	тохижилтын ажилд идэвх санаачилгатай оролцох	оролцоно.	Т
	➢ Ажлын байранд байх амралтын өрөөний цэвэрлэгээ, тохижилтын ажилд санаачилгатай оролцох	Биечлэн оролцоно.	Т
	➢ Байгууллагын гадна талбайн /хог ургамал, цас мөс, хатсан навч, хог шороо гэх мэт /цэвэрлэгээг хийнэ.		Т
	➢ Эм бараа, тоног төхөөрөмж татан авах, түгээхэд оролцох		Т
	➢ Олон нийтийг хамарсан ажил (спорт, урлаг, хурал, цуглаан, сургалт семинар гэх мэт)-д идэвхитэй оролцоно.	Биечлэн оролцоно.	Т
	➢ Байгууллагын үйл ажиллагаанд тус болох санал, санаачилга гаргахыг эрмэлзэн ажиллах. Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, дотоод журам, стандартыг дагаж мөрдөх		Т

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бүрэн дунд, тусгай дунд,
Мэргэжил	Жолооч /B,D ангилалтай байх /
Мэргэшил	Техникийн сургалтанд хамрагдсан байх,
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх
Ур чадвар	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - Хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - Механик, автоматжуулалтын мэдлэгтэй байх - Хууль эрх зүйн мэдлэгтэй байх - Ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх - Шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: 1.Төвийн ерөнхий захирал 2.Албаны дарга 3.Аж ахуйн менежер	Бусад харилцах субъект 1. Замын цагдаагийн газар 2. МИГ даатгалын компани 3. Бусад харилцагч байгууллага, аж ахуйн нэгжүүд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт баталсан	Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Б.Амгаланбаяр ..... /гарын үсэг/ 2025 оны 05 сарын 29-ны өдөр	Хүний нөөцийн менежер Э.Пагмадулам ..... /гарын үсэг/ 2025 оны 05 сарын 29-ны өдөр
Албан тушаалын тодорхойлолт танилцуулсан	**Албан тушаалын тодорхойлолттой танилцсан**
Санхүү, хангамж, нөөцийн албаны дарга Д.Болдбаатар ..... /гарын үсэг/ 2025 оны 05 сарын 29-ны өдөр	Түргэн тусламжийн жолооч Я.Норовцэрэн ..... /гарын үсэг/ 2025 оны 05 сарын 29-ны өдөр

---oOo---